

Mongolian  
Education  
Alliance



Монголын  
Боловсролын  
Хамтын  
Ажиллагааны  
Нийгэмлэгийн  
хэвлэл

# Í ŸŸËÒÒŸË ÑÓÐÃÓÓËÛ

Боловсролын чанарыг дээшлүүлж,  
нээлттэй нийгмийн үнэт зүйлсийг  
эрхэмлэнэ.

www.mongoleducation.mn  
2006 оны 11 дүгээр сар  
№10 (80) Үнэ: 350 төг


## ТАЛАРХАЛ

Боловсролын Хамтын Ажиллагааны Нийгэмлэгийн хэвлэл “Нээлттэй сургууль” сонины 80 дахь дугаар, Ховд аймагт сургалт арга зүйн байгууллага байгуулагдсаны 50 жилийн ойтой давхцан уншигч та бүхний хүртээл болж буйд манай байгууллагын зүгээс ихэд бэлэгшээж байна.

Ховд аймгийн Боловсрол, соёлын газар 1998 оноос хойш билэнтэй байнга хамтран ажиллаж манай байгууллагын ууган түншлэгчдийн нэгд зүй ёсоор тооцогдог билээ.

Ховд аймгийн нийт багш, сурган хүмүүжүүлэгчид, боловсролын салбарын ажилтнууд та бүхэндээ бианийг байнга дэмжин хамтран ажиллаж байдаг талархсанаа илэрхийлж, соён гэгээрүүлэх их үйлсэд тань улам их амжилтыг хүсэн ерөөе.

Боловсролын Хамтын Ажиллагааны Нийгэмлэгийн хамт олон



ÕÎ ÂÄ ÀÉÌ ÀÀÒ  
ÑÓÐÃÀËËÒ ÐÐÃÀ  
Ç-ÉÍ  
ÀÀÉÃÓÓËËÀÃÀ  
ÀÀÉÃÓÓËËÀÃÀÑÀÍ Õ  
50 ЖИЛИЙН ОЙ



## МЭНДЧИЛГЭЭ



Манай орны гэрэлт ирээдүй болсон өсвөр үеийнхэнд эрдэм боловсрол олгох, багш нарын мэргэжил дээшлүүлэх, боловсролын шинэчлэлийг орон нутагт хэрэгжүүлэх хүндтэй үүрэг хүлээсэн боловсролын салбарын ажилтнууд, багш нар, сургалт заах аргын байгууллагад ажиллаж байсан үе үеийн ахмадууд, мэргэжлийн арга зүйчид, ажиллагчид та бүхэнд Ховд аймагт сурган хүмүүжүүлэх ухааны кабинет (Боловсрол, соёлын газар) үүсч хөгжсөний 50 жилийн ойг тохиолдуулан аймгийн ИТХ-ын тэргүүлэгчид, Засаг даргын нэрийн өмнөөс мэндчилгээ дэвшүүлье.



Төр засгаас баруун бүс нутгийг хөгжүүлэхэд онцгойлон анхаарч БНМАУ-ын сайд нарын зөвлөлийн 1956 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн тогтоолоор “Сурган хүмүүжүүлэх ухааны кабинет” байгуулагдсан тэр үеэс эдүгээг хүртэл орон нутагт боловсрол соёлын салбарыг хөгжүүлэн аймгийнхаа хөгжилд тодорхой хувь нэмэр оруулж ирсэн байна.

Аймгийн 16-49 насны хүн амын 73.0% нь суурь буюу түүнээс дээш шатны боловсролтой болж сургуулийн насны хүүхдийн (7-15 нас) 95.0%-ийг ЕБС-д, сургуулийн өмнөх насны хүүхдийн (2-6 нас) 49.8%-ийг эцэслэлтгт хамруулан бүх шатны сургуулийн тогтоцоо бий болсон нь бодитой амжилт юм.

Боловсрол, соёлын салбарт оруулах хөрөнгө оруулалт нэмэгдэж, сургууль, шэсэрлэгийн сургалтын орчин сайжирч, боловсон хүчнээр бүрэн хангагдсан байна.

Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойг угтаж Боловсрол, соёлын байгууллагууд тодорхой ажлуудыг санаачлан зохион байгуулаа.

Боловсролын шинэчлэлийг гүнзгийрүүлэн, ЕБС-ийг 11 жилийн тогтоцооноа шилжүүлж боловсролын стандарт, сургалтын шинэ төлөвлөгөөг хэрэгжүүлэх, соёлын салбарыг хөгжүүлэх үйлсэд их амжилт гаргахыг хүсье.

Эрдэм ухааны өглөг арвин байх болтугай.

АЙМГИЙН

ИТХ-ЫН ТЭРГҮҮЛЭГЧИЙН ДАРГА

ЗАСАГ ДАРГА

## ГЭРЭЛ ЗУРАГ ТҮҮХ ӨГҮҮЛНЭ



Сурганы кабинетын анхны барилга



Жаргалант сумын I сургууль



